

2008.04.18

Дугаар 83

“Бодь даатгал” ХХК-д ердийн даатгалын зарим  
хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын тухай хуулийн 20.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Бодь даатгал” ХХК-д даатгалын дараах хэлбэрүүдээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай:

1/Монгол улсын нутагт түр хугацаагаар орох болон дамжин өнгөрч буй авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын (1.3.16);

2/ Бизнес тасалдлын (1.4.1);

3/ Чин шударгын баталгааны (1.4.5);

4/ Гүйцэтгэлийн баталгааны (1.4.6).

2.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, “Бодь даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрүүдийг нэмж бүртгэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ